

Нийгмийн Сүлжээ Хэрэглэгчдийн Өнөөгийн Байдал

(Монгол улс, Facebook сайтын жишээн дээр)

Б.Норжинбуу

Мэдээлэл зүйн тэнхим, МБУС, МУБИС

norjinbuu@msue.edu.mn

Хураангуй - Дэлхий нийтээр мэдээлэл, харилцааны технологи эрчимтэй хөгжиж түүний үр нөлөөгөөр хүн бүр ямар нэгэн нийгмийн сүлжээнд харьяалагдаж байна. Манай улсын хувьд ч нийгмийн сүлжээнд хамааралтай хүмүүс нийт хүн амын 29,56% хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн 63% нь 13-25 насныхан эзэллэж байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Цаашид Facebook, twitter гэх мэт нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн тоо улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа ба манай улсын хувьд нэг жилд өсөх өсөлтийн зэрэг нь 9,8% байгаа аж. Цаашид Монгол улсын нийгмийн сүлжээ (Facebook) хэрэглэгчдийн тоо улам бүр нэмэгдэх төлөвтэй байгаа учраас нийгмийн сүлжээг ёс зүйтэй, зөв ашиглах, зөв хандлагатай болох, цаашилбал, нийгмийн сүлжээг боловсрол, сургалтад ашиглах талаар багш нар анхаарах шаардлагатай болж байна.

Түлхүүр үгс: олон нийтийн сайт, facebook, хэрэглэгч, хэрэглээ, судалгаа

I. ОРШИЛ ХЭСЭГ

“Бидэнд нийгмийн сүлжээг ашиглах эсэх тухайд сонголт байхгүй, үүний оронд хэрхэн үр нөлөөтэй ашиглах тухай ярьсан нь дээр юм.” Erik Qualman хэлсэн байдаг [5].”


“2004 оны 2 сарын 4 нд Марк Зюкэрбэрг Facebook-ийг Харвардын Их Сургуульд компьютерийн чиглэлээр суралцдаг хоёр найзтайгаа “найзуудтайгаа байнга холбоотой байж болохуйц” вэб сайтыг тэд анх бүтээхээр зорьжээ. 2006 он хүртэл энэхүү сайт нь зөвхөн Харвард Коллежийн дотоод хүрээнд л ажиллаж байв. Ингээд 2006 оны 9 сараас хойш дэлхий дахинаа энэхүү том сүлжээ сайт нь нээгдэж байсан түүхтэй.[8]”

II. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Судалгааны арга зүй:


Энэхүү өгүүллийн судалгаа нь сэдэвтэй холбоотой баримт материалуудыг цуглуулж, хооронд нь харьцуулах, боловруулах, анализ хийх зэргээр баримтын судалгаа хийв. Facebook нь хамгийн алдартай, хурдацтай хөгжиж, хэрэглэгчийн хүрээгээ тэлж буй нийгмийн сүлжээ болохоор facebook-тэй холбоотой мэдээ, нийтлэл, баримт, хэрэглэгчдийн тоог хянасан сайтууд харьцангуй элбэг учир мэдээллийг хэд хэдэн эх сурвалжтай харьцуулж ашигласан болно.

Дэлхий нийтийн Facebook хэрэглээ:



Зураг №1 <http://vincos.it> Нийгмийн сүлжээнүүд сарын идэвхитэй хэрэглэгчдын тоогоор жагсаасан байдал

Facebook 1,19 тэрбум идэвхтэй хэрэглэгчтэй хамгийн том нийгмийн платформ, харин Qzone 623,3 сая хэрэглэгчтэйгээр хоёрдугаарт орж байна. БНХАУ нь QZone нийгмийн сүлжээг ашигладаг учраас Facebook-ийн дараа орж байна. Google+ идэвхтэй хэрэглэгчдийн тоо 300 сая, гуравдугаарт бичигджээ. Tencent Weibo сарын идэвхтэй хэрэглэгч 220 сая байдаг. Twitter-ээр нэг сард 118 сая идэвхтэй хэрэглэгчид жиргэдэг. Хамгийн хурдацтай хөгжиж буй нь нийгмийн платформоор сарын идэвхтэй хэрэглэгч 150 сая хүрсэн Instagram мөн foursquare 8 сая aficionados цуглуулдаг байна.



Зураг №2 <http://vincos.it> нийгмийн сүлжээ ашиглаж буй хүмүүсийн тухайн сайтад хандаж буй хандалтын давтамж

Дээрх судалгааны үр дүнгээс харахад Facebook хэрэглэгчдын 70% нь өдөр бүр сайтруу ханддаг, 17% нь долоо хоног бүр ханддаг бөгөөд бусад олон нийтийн сүлжээтэй харьцуулахад Facebook хэрэглэгчдийн өдөр бүр хандах хандалт нь өндөр байдаг.

Social media matrix
 % of users of each particular site who use another particular site (e.g., 34% of Pinterest users also use Twitter)

	Use Twitter	Use Instagram	Use Pinterest	Use LinkedIn	Use Facebook
% of Twitter users who ...	-	58%	42%	47%	91%
% of Instagram users who ...	52%	-	47%	38%	94%
% of Pinterest users who ...	34%	43%	-	40%	88%
% of LinkedIn users who ...	39%	35%	40%	-	86%
% of Facebook users who ...	29%	34%	34%	33%	-

Pew Research Center's Internet Project September Combined Omnibus Survey, September 11-14 & September 18-21, 2014.
 PEW RESEARCH CENTER

Зураг №5 <http://vincos.it> нийгмийн сүлжээ хэрэглэгчд өөр ямар сүлжээг давхар ашигладагыг харуулсан үзүүлэлт

Дээрх үзүүлэлтээс харахад бусад сайтуудын хамгийн их хувь нь Facebook-ийг хамран хэрэглэдэг гэсэн бол, Facebook хэрэглэгчдын 34% нь Instagram, Pinterest хоёрыг түүнтэй хослуулан хэрэглэдэг гэсэн байна.

Монгол улсын Facebook хэрэглээ:


“Монгол улс 2013 оны байдлаар 2,822,919 сая хүнтэй байсан ба түүний 443.682 нь 18-25 насны залуучууд эзэлдэг. [7]”



Зураг №6 “Цагаан ном 2014” хуудас 29 Интернет хэрэглэгчдийн тоо

Монгол улсын интернет бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 2013 оны байдлаар 762,100 байсан ба түүний 640,000 нь буюу 84% нь facebook хэрэглэдэг.

<http://analytics.socialdaily.com> сайтыг мэдээгээр 2015 онд Монгол улсын Facebook хэрэглэгчдийн тоо 940.000 ба нийт хүн амын 29,56% нь хэрэглэж байна. Мөн эдгээр 940.000 хүний 680.000 нь нийслэл Улаанбаатар хотод амьдардаг, үлдсэн 260.000 нь орон нутагт амьдардаг аж.



Зураг №9 Цагаан ном 2014 хуудас 31 Фэйсбүүк хэрэглэгчдийн насны ангилал

Facebook хэрэглэгчдийн:

- 26%-ийг 26-35 насны хэрэглэгчид
- 40%-ийг 19-25 насны хэрэглэгчид,
- 23%-ийг 13-18 настай хэрэглэгчид эзэлж байгаа нь манай улсын Facebook хэрэглэгчдийн 63% нь 25-с доош насны буюу оюутан сурагчид, 89% нь 13-35 насныхан эзэлж байна.

<http://analytics.socialdaily.com> сайтыг 2015 оны 2 сарын байдлаар Монгол улсын Facebook хэрэглэгчдийн 39% нь 18-25 настай хэрэглэгчид эзэлж байна. 2013 онд 640000 хэрэглэгчийн 40% нь, 2015 оны 2 сарын байдлаар 920,000 хэрэглэгчийн 39% нь 18-25 насны хэрэглэгчид байна гэхээр манай улсын өсвөр, залуучууд хамгийн ихээр нийгмийн, олон нийтийн сайтыг хэрэглэдэг байна.

Дэлхийн 1,2 тэрбум фэйсбүүк хэрэглэгчид янз бүрийн зорилгоор фэйсбүүкийг ашигладаг. Evans нарын Вашингтоны Их Сургуулийн магистр оюутнуудын 2012 онд хийсэн “*Facebook’s 8 Fundamental Hooks and 6 Basic User Types: A Psychographic Segmentation*” нэртэй судалгаанд facebook-ийн биднийг татаад байгаа зүйлийг тодруулж, хэрэглэгчдийг facebook ашиглаж буй байдлаар нь 6 төрөлд хуваасан байна. 2012 оноос хойш мөн энэ чиглэлээр судалгааны ажлууд хийгдсэн ч энэ үндсэн 6 зүйл дээр 2-3-ийг нэмж гаргасан байсан учраас суурь 6 дэгээ, хэрэглэгчдийн 8 төрлийг уг өгүүлэлд дараах байдлаар тодорхойлсон байна.

Facebook-ийн биднийг татаад байгаа зүйл нь юу вэ?

1. Медиа ба Мэдээллүүд
2. Олон нийтийн шинэчлэлүүд
3. Тоглоомууд
4. Группууд ба Бусад сайтын холбоосууд
5. Нээлттэй сүлжээнүүд
6. Хуваалцах
7. Урилга
8. Хувийн сүлжээ

Түүнчлэн Facebook-ийн хэрэглэгчдийн хамгийн ихээр оршин байдаг төрөл нь:

1. Fans(фенүүд)
2. Branders(брэндүүд)
3. Social-Searchers (хайгчид)
4. Influencers(нөлөө үзүүлэгчид)
5. Gamers(тоглоомчид)
6. Neutrals(төвийг сахигч)

Эдгээр 6 төрлөөс олон нийтийн сайтыг өөрт ашигтайгаар ашиглаж байгаа хүмүүс нь брэндууд буюу бизнесийнхэн юм. Тэд өөрсдийн бараа бүтээгдэхүүний танилцуулга, сурчилгааг олон хүнд түргэн, шуурхай хүргэж чаддаг мөн онлайн дэлгүүр, бараа захиалах, хүргэх үйлчилгээ манай улсын хувьд өргөн дэлгэрч байна.

Ш. ДҮГНЭЛТ

Манай улсын нийгмийн сүлжээ хэрэглэгчид залуу, өсвөр насныхан байна. Нийгмийн сүлжээ сайт хэрэглэгчдийн тоо өсөхийн хэрээр түүний эерэг болон сөрөг нөлөөлөл дагаад ихэсч байна.

Хэрэглэгчдийн хувд нийгмийн сүлжээний эерэг нөлөөлөл нь:

- Групп, баг, найз нөхдөөрөө сайн үйлсын тусламжийн аян өрнүүлэх (хүмүүст туслах, хандив цуглуулах, нийгмийн сайн сайхны төлөө үйлс хийх гэх мэт)

- Чөлөөт цагаа зөв, боловсон өнгөрүүлэх (ууланд авирах, алхах, гүйх, ном солилцож унших гэх мэт), түүнийгээ сурталчилах

- Нөлөөлөгчид олон болохын хэрээр тухайн хүн эерэг зүйлд хүмүүсийг уриалах, дагуулах (хүний наймааны эсрэг, хүүхдийн эрхийг хамгаалахын төлөө гэх мэт)

- Бизнесийн салбарт үр ашигаа өгч байгаа

- Хувь хүний хувьд өөрийгөө нээх, илрүүлэх, бусдтай ойлголцох

Сөрөг нөлөөллүүд:

- Худал мэдээлэл авах

- Цаг ашиглалт, ажлын бүтээмж багасах (зарим мэргэжлийн хувьд)

Хувь хүний хувьд:

- Хэт их мэдээлэлд живэх

- Тоглоомд донтох

- Буруу зүйлд сайтыг ашиглах

- Амьд харилцаа үгүй болох гэх мэт.

Нийгмийн сүлжээг зөв ашиглаж чадвал маш том боломж, зах зээл. Тиймээс ч бизнесийн салбарт олон нийтийн сайтыг ашиглан маркетинг хийх тухай олон сургалт зохион байгуулагддаг болсон. Мөн гадны зарим орнууд (Англи, Америк, Энэтхэг гэх мэт) Facebook, Twitter зэрэг сайтыг боловсролд тэр дундаа их дээд сургуулийн сургалтад ашиглаж эхэлсэн байна. Манай улсын хувьд ч боловсролын салбарт бүх төрлийн мэргэжилтэнүүдэд, зайны болон модуль сургалтууд зохион байгуулахад Facebook сайтыг ашиглах боломж байсаар байна.

Ном зүй:

[1] Мэдээлэл технологи, шуудан харилцаа холбооны газар “Цагаан ном-2014”

[2] Huseyin Bicen, Huseyin Uzunboylu “The Use of Social Networking Sites in Education: A Case Study of Facebook” *Journal of Universal Computer Science*, vol. 19, no. 5 (2013), 658-671

[3] Murat Kayri, Özlem Çakır “An Applied Study On Educational use Of Facebook As A Web 2.0 Tool: The Sample Lesson Of Computer Networks And Communication” *International journal of computer science & information Technology (IJCSIT)* Vol.2, No.4, August 2010

[4] David Evans, Nora Robertson ... нар “Facebook’s 8 Fundamental Hooks and 6 Basic User Types: A Psychographic Segmentation” paper

[5] Д.Мийгаа “Нийгмийн сүлжээ бол шинэ ертөнц” илтгэл

[6] <http://analytics.socialdaily.com>

[7] <http://vincos.it>

[8] <https://mn.wikipedia.org>